ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/3/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор З.Мөнгөнцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2026 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 11

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 16

4. АУДИТЫН ТАЙЛАН 17

4.1 Ерөнхий зүйл 17

4.2 Материаллаг байдал 18

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 18

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 18

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 19

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 19

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 19

7. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ 21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 190

танай _____-ны №_____ -т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ТҮМЭНЦОГТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн дамжуулан зээлийн өрөнд тус сумын орон нутгийн төсвөөс 342.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын төсвийн нийт зарлагын 49.2 хувь буюу 1,860.0 сая төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг авч, төсвийн

4528050321

төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийг олгосон байна.

Бусад асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны 19 зорилт, 83 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Орхон сумын ИТХ-аар 99.2 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**		**796,488,839.19**	**1,031,579,292.21**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	323,602,036.23	131,774,036.07
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	224,428,326.54	308,530,546.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	237,488,876.42	572,040,109.24
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	10,969,600.00	19,234,600.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	10	**4,685,941,691.37**	**4,626,960,287.53**
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		4,685,941,691.37	4,626,960,287.53
39200	Биет хөрөнгө	12а, 12б, 12в	4,464,925,001.60	4,407,907,707.61
39300	Биет бус хөрөнгө	13	221,016,689.77	219,052,579.92
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**		**5,482,430,530.56**	**5,658,539,579.74**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	14	**36,557,936.00**	**94,212,505.38**
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		36,557,936.00	94,212,505.38
41300	Өглөг		36,557,936.00	94,212,505.38
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**		**5,445,872,594.56**	**5,564,327,074.36**
51	Засгийн газрын хувь оролцоо		5,445,872,594.56	5,564,327,074.36
51100	Засгийн газрын оруулсан капитал		769,976,677.02	769,976,677.02
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		769,976,677.02	769,976,677.02
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		111,595,600.00	111,595,600.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		2,472,960,883.00	2,722,948,383.00
51200	Хуримтлагдсан үр дүн		464,106,728.62	332,573,708.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,627,232,705.92	1,627,232,705.92
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**		**5,482,430,530.56**	**5,658,539,579.74**



2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**		**4,590,066,968.87**	**5,099,265,108.86**
2	ТАТВАРЫН ОРЛОГО		887,122,317.39	964,872,080.03
3	Орлогын албан татвар		569,280,802.79	669,996,980.25
4	Хөрөнгийн албан татвар		185,841,890.11	156,217,937.41
5	Бусад татвар, төлбөр, хураамж		131,999,624.49	138,657,162.37
6	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,422,084,601.48	4,134,393,028.83
7	Тусламжийн орлого		0.0	1,890,462,043.00
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,280,860,050.00	
9	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**2а, 2б**	3,452,448,177.29	4,309,413,205.22
10	УРСГАЛ ЗАРДАЛ		3,452,448,177.29	4,309,413,205.22
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,951,778,887.29	3,846,013,945.22
12	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,235,780,066.60	1,089,907,312.11
13	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		154,527,183.95	133,317,915.07
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		708,534,535.47	615,597,722.31
15	Хангамж, бараа материалын зардал		115,258,070.48	62,316,066.06
16	Норматив зардал		7,133,640.00	-
17	Эд хогшил, урсгал засварын зардал		127,721,167.10	136,070,400.00
18	Томилолт, зочны зардал		12,036,000.00	6,969,000.00
19	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		140,186,266.44	1,486,480,509.18
20	Бараа үйлчилгээний бусад зардал		450,601,957.25	315,355,020.49
21	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		500,669,290.00	463,399,260.00
22	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**		**1,137,618,791.58**	**789,851,903.64**
23	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**		**1,121,256,401.72**	**908,122,539.84**
24	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)**		**(1,121,256,401.72)**	**(908,122,539.84)**
25	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)**		**16,362,389.86**	**(118,270,636.20)**



2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**2,120,481,890.02**	**1,627,232,705.92**	**447,744,338.76**	**4,195,458,934.70**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**2,120,481,890.02**	**1,627,232,705.92**	**447,744,338.76**	**4,195,458,934.70**
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	146,000,000.00	0.00	0.00	146,000,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,088,051,270.00	0.00	0.00	1,088,051,270.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,362,389.86	16,362,389.86
10	**2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**3,354,533,160.02**	**1,627,232,705.92**	**464,106,728.62**	**5,445,872,594.56**
11	**2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**3,354,533,160.02**	**1,627,232,705.92**	**464,106,728.62**	**5,445,872,594.56**
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(13,262,389.86)	(13,262,389.86)
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**3,354,533,160.02**	**1,627,232,705.92**	**450,844,344.62**	**5,432,610,210.56**
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	249,987,500.00	0.00	0.00	249,987,500.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(118,270,636.20)	(118,270,636.20)
20	**2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**3,604,520,660.02**	**1,627,232,705.92**	**332,573,708.42**	**5,564,327,074.36**

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН**	**3,839,334,205.45**	**4,307,127,881.05**
2	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**887,122,317.39**	**964,872,080.03**
3	Орлогын албан татвар	569,280,802.79	669,996,980.25
4	Хөрөнгийн албан татвар	185,841,890.11	156,217,937.41
5	Бусад татвар, төлбөр, хураамж	131,999,624.49	138,657,162.37
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	58,164,302.89	73,911,197.77
7	Газрын төлбөр	61,960,007.00	55,631,822.00
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,875,314.60	9,114,142.60
9	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**693,805,538.06**	**3,342,255,801.02**
10	Нийтлэг татварын бус орлого	693,805,538.06	818,177,458.02
11	Тусламжийн орлого	0.0	1,890,462,043.00
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	633,616,300.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**2,258,406,350.00**	**0.0**
14	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН**	**3,166,786,973.61**	**3,700,198,022.21**
15	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**3,166,786,973.61**	**3,700,198,022.21**
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,668,512,233.61	3,226,365,212.21
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,242,196,576.19	1,583,579,511.78
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,533,061.51	133,317,915.07
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	729,012,862.47	857,034,358.14
20	Хангамж, бараа материалын зардал	120,383,687.00	157,765,082.00
21	Норматив зардал	1,050,000.00	0
22	Эд хогшил, урсгал засварын зардал	96,166,750.00	139,269,000.00
23	Томилолт, зочны зардал	11,476,000.00	6,969,000.00
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,541,576.44	232,670,185.22
25	Бараа үйлчилгээний бусад зардал	113,151,720.00	115,760,160.00
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	498,274,740.00	473,832,810.00
27	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**672,547,231.84**	**606,929,858.84**
28	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН**	**1,038,091,791.00**	**676,477,859.00**
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,038,091,791.00	676,477,859.00
30	Дотоод эх үүсвэрээр	1,038,091,791.00	676,477,859.00
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,038,091,791.00)	(676,477,859.00)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗӨЭЛ	58,000,000.00	122,280,000.00
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(58,000,000.00)	(122,280,000.00)
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(423,544,560.16)	(191,828,000.16)
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	747,146,596.39	323,602,036.23
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	323,602,036.23	131,774,036.07

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 он 03 сар 24 өдөр Дугаар 141/01-Е092061-2811-2026/В/11-СЛА-ТВ Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 42,000,000.00 төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д *"Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно"*, 10.1.5-д *"энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах"*, 34 дүгээр зүйлийн 34.6-д "*Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно"*, 34.6.3-т "*төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1.10-т *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс дэмжлэг олгож байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, санхүүгийн албаны дарга Ц.Цэрэнпил нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР З.МӨНГӨНЦЭЦЭГ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

4526090453

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	**НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН**	**3,773,109,500.00**	**3,582,275,054.08**	**(44,904,545.92)**	**94.9**
11	Татварын орлого	973,900,000.00	964,872,080.03	(9,027,919.97)	99.1
12	Татварын бус орлого	155,903,400.00	123,786,674.05	(32,116,725.95)	79.4
120	Нийтлэг татварын бус орлого	155,903,400.00	123,786,674.05	(32,116,725.95)	79.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	140,903,400.00	57,683,642.30	(83,219,757.70)	40.9
120009	Бусад орлого	15,000,000.00	66,103,031.75	51,103,031.75	440.7
122	Тусламжийн орлого	2,643,306,100.00	2,493,616,300.00	(3,759,900.00)	94.3
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,863,759,900.00	1,860,000,000.00	(3,759,900.00)	99.8
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	633,616,300.00	633,616,300.00	-	100.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	145,929,900.00	-	(145,929,900.00)	-
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН**	**3,773,109,500.00**	**3,773,598,790.16**	**489,290.16**	**100.0**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,001,278,900.00	2,703,448,481.16	(297,830,418.84)	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,527,577,600.00	2,243,313,871.16	(284,263,728.84)	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,116,415,900.00	1,089,658,092.78	(26,757,807.22)	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,551,900.00	133,317,915.07	(6,233,984.93)	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	723,280,000.00	613,437,722.31	(109,842,277.69)	84.8
2104	Хангамж, бараа материалын зардал	36,107,500.00	24,376,750.00	(11,730,750.00)	67.5
2105	Норматив зардал	1,072,400.00	-	(1,072,400.00)	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,420,400.00	171,886,000.00	(2,534,400.00)	98.5
2107	Томилолт, зочны зардал	15,666,900.00	6,969,000.00	(8,697,900.00)	44.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,926,100.00	99,558,231.00	(25,367,869.00)	79.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,136,500.00	104,110,160.00	(92,026,340.00)	53.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,328,400.00	129,761,710.00	(13,566,690.00)	90.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	101,295,400.00	93,938,110.00	(7,357,290.00)	92.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,033,000.00	35,823,600.00	(6,209,400.00)	85.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	643,010,500.00	607,249,209.00	(35,761,291.00)	94.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗӨЭЛ	128,820,100.00	122,280,000.00	(6,540,100.00)	94.9
	Дамжуулан зөэлийн төлбөр		340,621,100.00		
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**-**	**320,609,178.28**	**320,609,178.28**	**-**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**-**	**129,285,442.20**	**129,285,442.20**	**-**

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	**НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН**	**28,462,043.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	
12213	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**28,462,043.00**
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,462,043.00
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**28,462,043.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**28,462,043.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**27,012,043.00**
2104	Хангамж, бараа материалын зардал	10,347,262.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,014,781.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,650,000.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**1,450,000.00**
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,450,000.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ТЕЗ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэгтэй, Дархан-Уул аймгийн ТЕЗ-д харьяалагдана.

Тус сум нь чиг үүргийн хүрээнд "Иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж, эрүүл, аюулгүй, орчинд амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, ирээдүйдээ итгэх итгэлийг бий болгох", "Хөдөө аж ахуйн салбарыг кластераар хөгжүүлсэн Монгол Улсын жишиг сум болох" гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сумын ТЕЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд 3 удаа өөрчлөлт орж, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" батлагдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтын талаар олж авсан ойлголтод үндэслэн гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн шууд захирагч бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176.1 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	323.6	131.8	(191.8)

Авлага	224.4	308.5	84.1
Бараа материал	237.5	572.0	334.5
Нөөцийн бараа	11.0	19.2	8.2
Үндсэн хөрөнгө	4,685.9	4,627.0	(58.9)
Нийт хөрөнгө	**5,482.4**	**5,658.5**	**176.1**
Өр төлбөр	36.5	94.2	57.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,445.9	5,564.3	118.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**5,482.4**	**5,658.5**	**176.1**

Мөнгөн хөрөнгийн данс 191.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны мөн үеэс орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 103.4 сая төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 70.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 17.8 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Харин авлагын дансны 84.1 сая төгрөгийн өсөлтөд Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал 334.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 463.7 сая төгрөгийн материал худалдан авч, ЗДТГ-т аймгийн ОНӨГ-ын даргын 2025 оны А/41 дүгээр тушаалаар "Шинэ хөдөө" төслийн хүлэмж, усалгааны системийг үндсэн хөрөнгөөс бараа материалын дансанд шилжүүлэн авч, 434.0 сая төгрөгийн материал зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын эцсийн үлдэгдэлд сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материал 72.0 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө 58.9 сая төгрөгөөр буурсан нь аймгийн Засаг даргын 2026 оны 01-А/04 дугаар захирамжаар ЗДТГ-т УТХО-аар бичил үйлдвэр, үйлчилгээ дэмжих зорилгоор 297.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн гүн хөлдөөгч, "Орхон тохижилт" ОНӨААТҮГ-т аймгийн ОНӨГ-ын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар "Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-аас 249.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэж, тайлан хугацаанд нийт 584.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь голлон нөлөөлжээ.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгө 33.2 сая төгрөгөөр, "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын татварын болон нүүрсний өр 24.5 сая төгрөгөөр өссөнөөс нэгтгэсэн тайлан дахь өр төлбөрийн данс 57.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 118.4 сая төгрөгөөр өссөн нь "Орхон тохижилт" ОНӨААТҮГ-т аймгийн ОНӨГ-ын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар "Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-аас 249.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан хөрөнгө, тайлант оны 118.3 сая төгрөгийн алдагдал нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 131.8 сая төгрөг болж, өмнөх оноос 191.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	**0.0**	**0.0**	**0.0**
Банканд байгаа бэлэн мөнгө	**323.6**	**131.8**	**(191.8)**
Төгрөг	**323.6**	**131.8**	**(191.8)**
Төрийн сангийн харилцах	323.0	131.7	(191.3)
Арилжааны банк дахь харилцах	0.6	0.1	(0.5)

Дүн	**323.6**	**131.8**	**(191.8)**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 131.8 сая төгрөгийн 131.7 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 0.1 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцахад байгаа 131.7 сая төгрөгийн 68.0 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 46.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 14.6 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, 2.4 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа дансны үлдэгдэл бөгөөд арилжааны банкин дахь 0.1 сая төгрөг нь "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дансны үлдэгдэл байна.

<u>Аудитын илрүүлэлт</u>:
ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *"Орхон сумын ИТХ" нь дээд газрын тушаал шийдвэргүйгээр 2.3 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон;*
- *"Орхон сумын ИТХ" нь өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 42.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.*

Шийдвэрлэсэн нь: *Дээрх зөрчлүүдээс 42.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.*

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 308.5 сая төгрөг болж, өмнөх оноос 84.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.5	0.3	(0.2)
Татаас санхүүжилтийн авлага	0.5	-	(0.5)
Зээлийн хүүгийн авлага	9.0	20.6	11.6
Дансны авлага /ТӨҮГ/	17.6	17.3	(0.3)
Байгууллагаас авах авлага	22.9	22.4	(0.5)
Хувь хүмүүсээс авах авлага	173.9	125.6	(48.3)
Зээлийн авлага	-	122.3	122.3
Дүн	**224.4**	**308.5**	**84.1**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны авлагын өсөлтөд Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 85.2 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Нийт авлагын 87.0 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага, 7.4 хувийг төсвийн байгууллагын авлага, 5.6 хувийг ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна.

<u>Аудитын илрүүлэлт:</u>
ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- ***"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь ОНӨГ-тай байгуулсан гуравласан гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй 0.2 сая төгрөгийн байрны түрээсийн алдангийг нэмж тооцоогүй;***

- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь "Тэс оргил" ХХК-аас авах 8.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;*
- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь санхүүгийн байдлын тайланд 0.9 сая төгрөгийн авлагыг дутуу тусгасан байна.*

Шийдвэрлэсэн нь: *Дээрх алдаа, зөрчлөөс 0.9 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.*

3.4.3 Бараа материал

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 237.5 сая төгрөг байснаас оны эцэст 572.0 сая төгрөг болж, 334.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий зд материал	**0.1**	**0.1**	-
Эм боох материал	0.1	0.1	-
Хангамжийн материал	**221.4**	**553.8**	332.4
Бичиг хэргийн материал	70.6	86.2	15.6
Аж ахуйн материал	26.3	14.1	(12.2)
Сэлбэг хэрэгсэл	3.0	7.5	4.5
Түлш, шатах тослох материал	19.8	33.2	13.4
Барилгын засварын материал	0.3	0.7	0.4
Бусад хангамжийн материал	101.4	412.1	310.7
Мал амьтад	**16.0**	**18.1**	**2.1**
Дүн	**237.5**	**572.0**	**334.5**
Нөөцийн бараа	**11.0**	**19.2**	**8.2**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 16.4 хувь нь ОНӨААТҮГ-т, 65.9 хувь нь төсвийн байгууллагад бүртгэлтэй байна.

Бараа материалын өсөлтөд ЗДТГ-т аймгийн ОНӨГ-ын даргын 2025 оны А/41 дүгээр тушаалаар "Шинэ хөдөө" төслийн хүлэмж, усалгааны системийг үндсэн хөрөнгөөс бараа материалын дансанд шилжүүлэн авсан нь голлон нөлөөлжээ.

Нөөцийн барааны дансны үлдэгдэл 8.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ЗДТГ-ын тэжээлийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,627.0 сая төгрөг болж, өмнөх оноос 58.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	**4,464.9**	**4,407.9**	**(57.0)**
Барилга, байгууламж, орон сууц	623.8	764.7	140.9
Авто-тээврийн хэрэгсэл	963.0	586.9	(376.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	434.9	790.5	355.6
Тавилга, аж ахуйн зд хогшил	13.1	23.0	9.9

Зам гүүрийн байгууламж	260.6	223.4	(37.2)
Бусад үндсэн хөрөнгө	2,169.5	2,019.4	(150.1)
Биет бус хөрөнгө	**221.0**	**219.1**	(1.9)
Программ хангамж	6.9	5.0	(1.9)
Бусад биет бус хөрөнгө	214.1	214.1	-
Дүн	**4,685.9**	**4,627.0**	**(58.9)**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 35.4 хувь нь төсвийн байгууллагуудад, 64.6 хувь нь ОНӨААТҮГ-т бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 98.7 хувийг биет хөрөнгө, 1.3 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:
ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь цэвэрлэх байгууламж 32.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгөөс бараа материалд шилжүүлсэн 0.1 сая төгрөг, актлалсан 0.5 сая төгрөг, нийт 32.9 сая төгрөгийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн;*
- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь бараа материалын ангиллаас 3.0 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэхдээ орлогын дэлгэрэнгүй тайланд бүртгэсэн байна.*

Шийдвэрлэсэн нь: *Дээрх алдаанаас 35.9 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийсэн.*

3.4.5 Өр төлбөр

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 36.5 сая төгрөг байснаас тайлант онд 57.7 сая төгрөгөөр өсөж, оны эцэст 94.2 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	1.0	0.8
Байгууллагад төлөх өглөг	36.3	86.5	50.2
Бараа үйлчилгээний зардлыг өглөг	-	6.7	6.7
Дүн	**36.5**	**94.2**	**57.7**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгө 33.2 сая төгрөгөөр, "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын татварын болон нүүрсний өр 24.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:
ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *"Орхон сумын ОНХС" нь "Онцот баян хайрхан" ХХК-ны 10.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;*
- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь санхүүгийн байдлын тайланд 5.8 сая төгрөгийн өр төлбөрийг дутуу бүртгэсэн байна.*

***Шийдвэрлэсэн нь:** Дээрх алдаанаас 16.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийсэн.*

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,564.3 сая төгрөг болж, өмнөх оноос 118.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	770.0	770.0	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	111.6	111.6	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,473.0	2,722.9	249.9
Хуримтлагдсан үр дүн	464.1	332.6	(131.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,627.2	1,627.2	-
Дүн	**5,445.9**	**5,564.3**	**118.4**

Эх сурвалж: Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 118.4 сая төгрөгөөр өссөн нь "Орхон тохижилт" ОНӨААТҮГ-т аймгийн ОНӨГ-ын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар "Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-аас 249.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан хөрөнгө, тайлант оны 118.3 сая төгрөгийн алдагдалтай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 16.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.*

***Шийдвэрлэсэн нь:** Дээрх 16.1 сая төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ОНХС-ийн орлогыг 1,021.6 сая төгрөг, татварын болон татварын бус орлогыг 963.2 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 140.9 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдэл 60.8 сая төгрөг, аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 2,256.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4,443.4 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг сумын ИТХ хэвээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвийг тайлант хугацаанд 1 удаа тодотгож, санхүүжих эх үүсвэрийг 25.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зарлагыг 670.3 сая төгрөгөөр бууруулж, 3,773.1 сая төгрөгөөр тодотгосон байна. Тодотголоор ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээг 388.0 сая төгрөгөөр, ИТХ-ын санхүүжилтийг 5.2 сая төгрөгөөр, ЗДТГ-ын санхүүжилтийг 161.4 сая

төгрөгөөр, гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагуудын ашиглалтын зардлыг 83.6 сая төгрөгөөр, урьд оны шилжих үлдэгдлийг 32.1 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

Энэ нь улс орны эдийн засгийн байдалтай уялдуулж улсын төсвийн тодотголоор төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх бодлогын хүрээнд зардлуудыг бууруулсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс 1,860.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, ОНХС-аас 633.6 сая төгрөгийн санхүүжилт авч, татварын болон татварын бус орлогоор 1,031.0 сая төгрөгийн, үйл ажиллагааны орлогоор 57.7 сая төгрөгийн, нийт 3,582.3 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,433.0 сая төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь ЗДТГ 5 орон тоо, ИТХ 1 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ-ийг зардлыг дутуу зарцуулсан, мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар тэвчиж болох зардлыг хэмнэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүжилт, зарцуулалтын эрхийг хязгаарлаж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Орхон сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 16.9 сая, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 13.6 сая, нийт 30.5 сая төгрөгийн орлого төвлөрчээ.

Орхон сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас өөлжилтийн бэлтгэл хангах зардалд 10.0 сая төгрөг, ойн хээрийн түймрийн эрсдэлтэй холбоотой эргүүл хийх шатахууны зардалд 0.3 сая төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1.6 сая төгрөг, хуулийн этгээдээс багийн байрны засварт 5.0 сая төгрөгийн, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 13.6 сая төгрөгийн, нийт 30.5 сая төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу тус тус зарцуулж, ИТХ зарцуулаагүй 2.0 сая төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Мөнгөнцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын Засаг дарга 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/57 тоот албан бичгээр 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2025 оны тодотгосон төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны тодотгосон төсөв 3,773.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 56.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Орхон сумын ЗДТГ нь байгууллагын ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй тул зөвлөмж хүргүүлсэн.
2. Орхон сумын ИТХ нь төсвийн хөрөнгөөр албан хаагчдын хүүхдүүдэд 0.4 сая төгрөгийн бэлэг худалдан авсан, "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь байгууллагын ажилчдын хүүхдүүдэд 0.7 сая төгрөгийн бэлэг худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалттай нийцээгүй тул ИТХ-д албан шаардлага хүргүүлж, "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-т төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан ч "төсвийн байгууллагын

батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар"-ыг 12 сар мэдээлээгүй, "төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл", "улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл"-ийн 5 дугаар сарын мэдээллийг тус тус хугацаа хоцроосон байна.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийхээр төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг шалгахад зөвлөмжийг биелүүлээгүй тул аудитаар албан шаардлага хүргүүллээ.

Хүснэгт 8. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	31.5	-	-	0.0
Нийт дүн	**1**	**31.5**	**-**	**-**	**0.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 176.9 сая төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, хүлээн зөвшөөрөхдөө ЗДТГ 42.3 сая төгрөгийн орлогын дансыг ангилал буруу бүртгэсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.42(ж), "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд "Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө" дансыг бууруулж, "Бусад орлого" дансыг нэмэгдүүлж залруулав.

2. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын нийт 134.6 сая төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "ААН-ийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 5 дугаар бүлгийн 1 дэх заалттай нийцэхгүй, "Ангилал", "Толилуулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул бараа материал худалдан

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

авахад төлсөн зардал, бусад мөнгөн зардлыг тус тус бууруулж, түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн зардал, татварын байгууллагад төлсөн зардлыг тус тус нэмэгдүүлж залруулав.

Аудитаар 42.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 42.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д *"Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно"*, 10.1.5-д *"энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах"*, 34 дүгээр зүйлийн 34.6-д *"Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно"*, 34.6.3-т *"төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу-лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	2	176.9	1	134.6	1	42.3	2	176.9				
ОНХС	2	316.7	1	10.6	1	306.1	2	316.7				
"Орхон хот тохижилт" ОНӨӨААТҮГ	5	46.6	4	13.7	1	32.9	5	46.6				
Дүн	**9**	**540.2**	**6**	**158.9**	**3**	**381.3**	**9**	**540.2**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

---

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	1	42.0			1	42.0						
ИТХ	3	44.7			2	42.4	1	2.3				
ЗДТГ	1	6.7					1	6.7				
ХХС	2	66.3			2	66.3						
"Орхон хот тохижилт" ОНӨӨААТҮГ	5	187.1	2	0.9	2	170.1	1	16.1				
Дүн	**12**	**346.8**	**2**	**0.9**	**7**	**320.8**	**3**	**25.1**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТЕЗ	1	0					1	0
ОНХСан	1	95.9					1	95.9
ЗДТГ	1	23.1			1	23.1		
Дүн	**3**	**119.0**			**1**	**23.1**	**2**	**95.9**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	**3**	**119.0**			**1**	**23.1**	**2**	**95.9**

7. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
			Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	2			1	1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ОНТС	2	1	1			1		
4	ОНӨҮГ	1	1			1			
5	ТЕЗ	1	1			1			
	НИЙТ	**6**	**5**	**1**		**3**	**2**		